

**ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН  
2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ**

№	Хийгдсэн ажил	Биелэлт
1	Орон тооны бус зөвлөлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Орон тооны бус зөвлөлийн 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг 6 заалттай боловсруулж, газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан
2	“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх	<p>БШУГ-ын даргын 2021 оны А/126 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт хийхэд тайлант хугацаанд байгууллагын нийт 23 албан хаагчдыг ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр мэргэжлийн чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах зорилгоор Төрийн албаны зөвлөлийн арга зүйн сургалтад 80%, “Алсын хараа 2050” сургалтад 100%, Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан “Боловсролын менежмент, манлайлал” сургалтад төрийн захиргааны албан хаагчид 100%, бусад чиглэлийн сургалтад бүрэн хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 98%-тай байна.</p>
3	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн залгамж холбоог сайжруулах чиглэлээр хийгдэж буй ажилд хяналт хийх	<p>ЕБС-ийн нэгдүгээр анги авах багш цэцэрлэгт 1 өдөр хүүхдүүд болон эцэг эхтэй ажиллах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг сургуультай танилцуулах аялал зохион байгуулах, цэцэрлэг, сургуулийн багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах үйл ажиллагааг 12 хамтарсан хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 45 удаа зохион байгуулсан байна.</p> <p>Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ хийх явцтай цэцэрлэгийг арга зүйч, бүлгийн багш нар танилцаж сурагчийн гүйцэтгэл, үнэлгээний даалгаварт анализ хийж, сургуулийн сургалтын менежерүүдтэй хамтран ажилласан. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд орон нутгийн өмчийн 16 сургуулийн 61 бүлэг, 2135 суралцагч, 17 ажлын хэсэгт 85 хүн, бага ангийн багш 60, биеийн тамирын багш 29, дуу хөгжийн 19 багш, нийт сурагч 2135, багш 113, нийт 2248 хүн оролцсон. 2022 оны сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд аймгийн хэмжээнд “Нийгэмшгүй хөгжил”-10%, “Хэл яриа” 20%, “Байгаль, нийгмийн орчин” 30%, “Математикийн төсөөлөл” 40%, “Хөгжим” 50%, “Дүрслэх” 32% үнэлэгдлээ. 2021 онд сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 60.1%, 2022 онд 72.1% гүйцэтгэлтэй байсан ба 2022 оны сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний гүйцэтгэл өмнөх оноос 11.9%-иар ахисан үзүүлэлттэй байна</p>

4	<p>Судлагдахуун хариуцсан мэргэжилтэнүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнд анализ дүгнэлт хийж буй байдалд хяналт хийх</p>	<p>Судлагдахуун хариуцсан мэргэжилтэн бүр ЭЕШ-ын үр дүнд анализ дүгнэлт хийж ажилласан байна.</p> <p>2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтад 1097 төгсөгч бүртгүүлж, элсэлтийн ерөнхий шалгалтад 1786 шалгуулагч оролцож, 10 судлагдахууны хэмжээст онооны дундаж 553 байгаа нь улсын дунджаас 36 оноогоор өндөр бөгөөд өмнөх онтой харьцуулахад 2.67 оноогоор өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>6 судлагдахууны төрлөөр 12 сурагч дээд оноо буюу 800 оноо авч, сурагч болон бэлтгэсэн багш нарыг аймгийн ИТХ, ЗДТГ-аас 16.5 сая төгрөгийн мөнгөн шагналаар урамшуулсан.</p> <p>Монгол хэл, бичгийн шалгалт хэмжээст онооны дундаж 519 байгаа нь улсын хэмжээнд 3-т эрэмбэлэгдэж, 2 хүүхэд 800 оноо авсан. Хэмжээст оноогоор улсын дундажаас дээгүүр 9 судлагдахуун байна. Улсын шалгалт: 2022-2023 оны хичээлийн жилийн улсын шалгалтад ерөнхий боловсролын 24 сургуулийн - 5 дугаар ангийн 65 бүлгийн 2326 сурагч хамрагдаж 81.3% , - 9 дүгээр ангийн 68 бүлгийн 2048 сурагч хамрагдаж 80,2%, - 12 дугаар ангийн 45 бүлгийн 1180 сурагч хамрагдаж 85,9%, нийт 5554 сурагч хамрагдаж 81,5%-ийн гүйцэтгэлтэй шалгагдсан байна</p> <p>ЭЕШ-ын чанарыг сайжруулах, сурагчдын ЭЕШ-д амжилттай оролцох бэлтгэлийг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран ЭЕШ-ын 2 удаагийн урьдчилсан сорилыг явуулж давхардсан тоогоор 2163 сурагч хамрагдаж өөрийн сонгосон 3 хичээлээр шалгалт өгсөн.</p> <p>Энэ ажлын үр дүнд ЭЕШ-ын 10 судлагдахууны 9 судлагдахуун дээр аймгийн дундаж өмнөх оноос өссөн. 2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтын 10 судлагдахууны хэмжээст онооны дундаж 553.00 байгаа бөгөөд энэ нь улсын дунджаас 36.00 оноогоор өндөр байна. Хэмжээст онооны дундажийг өмнөх онтой харьцуулахад 2.67 оноогоор өсч, 6 судлагдахууны төрлөөр 12 сурагч 800 оноо, дүйлцүүлсэн оноогоор 25 сурагч 800 оноо авсан байна.</p> <p>Төгсөх ангийн сурагчдын Монгол хэл, бичгийн шалгалт 04 дүгээр сард явагдаж, 1135 сурагч хамрагдсанаас 2 сурагч 800 оноо авсан байна. Монгол хэл, бичгийн хичээлийн хэмжээст онооны дундаж 519 байгаа нь улсын хэмжээнд 3-рт эрэмбэлэгдэж байна.</p> <p>Сургалтын чанарыг Боловсролын үнэлгээний төвөөс авсан шалгалтын үнэлгээгээр тооцдог ба 2023 онд аймгийн нийт 5, 9, 12-р ангиудаас авсан шалгалтын дундаж гүйцэтгэлийн хувь 85 хувьтай үнэлэгдсэн байна</p>
5	<p>Байгууллагын үйл ажиллагаагаа цахимжуулах,</p>	<p>Орхон аймгийн төрийн байгууллагуудын и-оффис системд боловсролын салбарын 52 байгууллага дотоод болон гадаад</p>

	<p>и-оффис системийг байгууллагын хэмжээнд хэрхэн ашиглаж буйд хяналт хийх</p>	<p>ажлын зохион байгуулалтаа хэрэгжүүлэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж хэвшсэн.</p> <p>2023 оны 12 сарын 08-ны байдлаар БШУГ-ын и-оффис программд төлөвлөсөн бичиг 215, үүрэг даалгавар 52, ажлын төлөвлөгөө 228, дотоод мэдээ 15, лавлах файлын сан 12 нийт 522 мэдээллийг оруулж дотоод үйл ажиллагаандаа ашигласан байна.</p> <p>И-оффисын албан хэрэг хөтлөлтийн системд ирсэн бичиг 1288, явсан бичиг 671, өргөдөл гомдол 248 орсон.</p> <p>Архивын системд байнга хадгалах 264 хадгаламжийн нэгж буюу 35127 хуудас эх, 70 жил хадгалах 413 хадагамжийн нэгж буюу 45305 хуудас эх, түр хадгалах 82 хадгаламжийн нэгж буюу 16666 хуудас эх нийт 759 хадгаламжийн нэгж буюу 97093 хуудас эх бүхий баримт бичгийг оруулсан.</p> <p>И-оффисын ашиглалтын сургалтыг 52 нэгж байгууллагад хийсэн байна</p>
6	<p>2023 онд хийсэн ажлын тайлан нэгтгэх</p>	<p>2023 онд хийсэн ажлын тайлан нэгтгэж, архивын нэгж болгосон байна</p>